# Хүүхдэд зориулсан Библи

танилцуулж байна



# Худаг дээрх эмэгтэй

Зохиогч: Edward Hughes

Зураглаач: Lazarus

Найруулсан: Ruth Klassen

Орчуулсан: Damdin Horolsuren

Бүтээсэн: Bible for Children
www.M1914.org

©2015 Bible for Children, Inc.
Зөвшөөрөл: Та энэ бүтээлийг хувилах хуулах эрхтэй харин худалдахыг хориглоно.

**Есүс шавь нартайгаа Самари нутгаар явж байлаа. Тэгээд тэд Сухар нэртэй нэгэн хотод ирэв.**



**Тэнд нэгэн худаг байсан бөгөөд Сухар хотын хүмүүс энэ худгаас ундалдаг байв. Израилийн өвөг эцэг Иаков энэ худгыг ухжээ.**



**Үд дунд болж нар шарж маш халуун байлаа. Шавь нар нь Сухар хот уруу хүнс худалдан авахаар явсан хойгуур Есүс худгийн ойролцоо эргэн тойрныг харан сууж байв.**





Есүс ганцаараа байлаа. Удалгүй Сухар хотод амьдардаг нэгэн эмэгтэй ус авахаар ирэв. Есүс түүнд "Надад уух юм өгөөч" гэлээ.



Тэр эмэгтэй ихэд гайхжээ. "Та Иудей хүн байж Самари эмэгтэй надаас яахин уух юм асууна вэ?" хэмээн эмэгтэй хариулав. Тэр үед Иудейчууд Самари хүмүүстэй харьцдаггүй байв.

Тэр эмэгтэй Есүсийг "Хэрэв чи ус өгөөч хэмээн асууж байгаа хүн хэн гэдгийг мэдсэн бол би чамд амийн усыг өгөх байсан" гэхийг сонсоод бүр гайхсан байхаа.





Тэр эмэгтэй Есүст
"Эзэн энэ худаг гүн
танд ус утгах юм алга.
Гэтэл та амийн усыг
хаанаас авах вэ?" "Та
бидний өвөг Иаковаас агуу
гэж үү? Тэр энэ худгийг
бидэнд өгсөн юм" гэв.



Есүс "Энэ уснаас уух хүн бүр дахин цангана" гээд "Харин өөрт нь Миний өгөх уснаас уугч хэн ч хэзээ ч цангахгүй. Харин Миний өгөх ус тэр хүний дотор мөнх аминд хүртэл оргилох булаг болно" гэхэд эмэгтэй Түүнд "Эзэн, тэр усаа надад өгөөч" гэв.

**Есүс явж нөхрөө дуудаад ир гэж айлдав. Тэр эмэгтэй "Би нөхөргүй" гэв. Есүс "Чи таван нөхөртэй байсан бөгөөд одоо чамтай байгаа хүн ч нөхөр чинь биш" гэв.**



Тэр эмэгтэй Есүсыг эш үзүүлэгч болохыг ойлгов. Тэр эмэгтэй Түүнтэй Бурханд хаана мөргөх вэ? Иерусалемд уу эсвэл Самаричуудын ариун ууланд уу гэж маргав. Есүс үнэн мөргөгчид нь сүнсээрээ, үнэнээр Эцэгт минь мөргөдөг гэв.



Тэр эмэгтэй Есүст "Христ гэгч Мессиа ирэхийг би мэднэ. Тэр Нэгэн ирэхдээ бүх зүйлсийг бидэнд мэдүүлж өгнө" гэхэд Есүс түүнд "Чамтай ярьж байгаа Би бол Тэр мөн" гэв. Тэр үед шавь нар нь буцан ирэв. Тэгтэл өнөөх эмэгтэй усныхаа үнэт савыг худаг дээр орхин хот уруу явжээ.





Өнөөх эмэгтэй Сухар хот уруу ирж "Миний үйлдсэн бүхнийг надад хэлсэн хүнийг ирж үзэгтүн, Тэр Христ биш үү?"  гэсэнд хүмүүс хотоос гарч Есүс уруу очиж байв.

Энэ үед шавь нар нь Есүсээс Багшаа авч ирсэн хоолноос зооглооч гэхэд Есүс "Миний хоол бол Намайг илгээсэн Түүний хүслийг үйлдэн, ажлыг нь гүйцэлдүүлэх явдал мөн" гэв. Түүний хийх ёстой ажил нь хүмүүсийг Бурхан уруу авч ирэх явдал байв.





Өнөөх Самари эмэгтэйн хэлсэн үгийг сонсоод Самаричуудаас олон хүн Есүст итгэжээ. Тэд Есүсээс тэдэнтэй хамт байхыг гуйсанд Есүс тэнд хоёр хоног байжээ.



Олон хүн Есүсийн үгийг сонсоод итгэж байлаа. Тэд "Одоо бид өөрсдөө сонсоод энэ Нэгэн бол үнэхээр ертөнцийн Аврагч мөн гэдгийг мэдлээ" гэцгээж байв.

# Худаг дээрх эмэгтэй

## Бурханы үг Библээс авсан түүх

## Иохан 4

"Таны үгсийн тунхаглал гэгээрүүлдэг."
Дуулал 119:130

# Төгсөв

Библийн түүх нь гайхамшигт Бурхан биднийг бүтээсэн бөгөөд таныг өөрийгөө мэдээсэй гэж хүсдэг тухай бидэнд хэлдэг.

Бурхны гэм гэж нэрлэдэг муу зүйлийг бид үргэлж хийдгийг Бурхан сайн мэднэ. Гэмийн шийтгэл нь үхэл боловч Бурхан танд маш их хайртай учир Тэрээр цорын ганц хүү Есүсийг таны гэмийн өмнөөс шийтгүүлэн загалмайд цовдлогдон үхэхийг зөвшөөрөн энэ дэлхийд илгээсэн юм. Тэгээд Есүс дахин амилж тэнгэр дэх гэртээ буцсан! Хэрвээ та Есүст итгэж түүнээс гэмийнхээ төлөө уучлал гуйвал Тэрээр таныг уучлах болно! Тэрээр таньруу ирэх бөгөөд тантай хамт байх болно мөн та түүнтэй мөнхөд хамт амьдрах болно.

Хэрвээ та энэ үнэнд итгэж байвал Бурханд хандан ийнхүү хэлээрэй: Эрхэм Есүсээ, Би таныг Бурхан гэдэгт болон миний гэмийн төлөө үхсэн гэдэгт мөн одоо та амьд гэдэгт итгэж байна. Миний амьдралд орж ирээд миний гэмийг уучлаач, тэгээд Би одооноос эхлээд шинэ амьдралаар амьдарч нэг өдөр тантай хамт мөнхөд байхаар явах болно. Танд дуулгавартай байж таны хүүхэд шиг таны төлөө амьдрахад туслаач. Амен.

Библи уншиж өдөр бүр Бурхантай ярилцаарай! Иохан 3:16